



**БОДЬ ДААТГАЛ**  
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

**БОДЬ ДААТГАЛ**

**2022**

**БОДЬ ДААТГАЛ ХК  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

## АЛСЫН ХАРАА

### АЗИД БҮРТГЭЛТЭЙ ЕРДИЙН БОЛОН АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛНО.

2023 он гэхэд Хонконгийн хөрөнгийн биржийн 2-р самбарт бүртгэлтэй, Азид өрсөлдөгч санхүүгийн цогц хамгаалалт үзүүлэгч компани болно.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

### ХАМТЫН ХҮЧЭЭР ИРЭЭДҮЙГ БАТАЛГААЖУУЛНА.

Хамтын хүчээр санхүүгийн нөөцөө бүрдүүлж харилцагч бүр ирээдүйгээ төлөвлөхөд нь тусалж түүнд учирч болох эрсдэлээс хамгаалах хүчирхэг санхүүгийн компани эрсдэлийн зөвлөх болно.

## ҮНЭТ ЗҮЙЛС

**ХАРИЛЦАГЧ ЭРХЭМ** - Харилцагчаа халамжлан сэтгэл хангалуун байлгахын төлөө нөөц боломжийг бүрэн ашиглана.

**МЭРГЭЖЛИЙН БАЙХ** - Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, ур чадвараа дайчлан олон улсын түвшинд ажиллана.

**УХААЛАГ АЖИЛЛАХ** - Шинийг санаачилж, бүтээмжтэй, багаар ажиллана.

**ХАМТЫН ХӨГЖИЛ** - Урт хугацааны тогтвортой, хамтын хөгжлийг эрхэмлэнэ.

**ХАРИУЦЛАГА** - Бүх түвшинд нягт нямбай, хариуцлагатай, нээлттэй байна.



# БОДЬ ДААТГАЛЫН ТУХАЙ

## (Компанийн танилцуулга)

### ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Байгуулагдсан он:	1995
Нийт хөрөнгө:	\$ 8.9 сая
Ажилчдын тоо:	120
Салбарын тоо:	25
Нийт хураамжаар:	12% (№3)
Цэвэр хураамж:	13% (№2)

### ДАВУУ ТАЛУУД

#### Үйл ажиллагааны давуу тал:

Цахим даатгал:	14 даатгал
Нөхөн төлбөр дээд хурд:	20 минут

#### Үйл ажиллагааны давуу тал:

Даатгалын үйл ажиллагаа:	1/3
Хөрөнгө оруулалт:	1/3
Давхар даатгалын үйл ажиллагаа:	1/3

#### 3 жилийн дундаж:

Зардал:	+14%
Цэвэр хураамж:	+27%

### БИЗНЕСИЙН СЕГМЭНТҮҮД (Цэвэр хураамжаар\*)

#### Байгууллага (43%)

Хариуцлага:	(7%)
Хөрөнгө:	(7%)
Тээврийн хэрэгсэл:	(3%)
Гэнэтийн осол, эрүүл мэнд:	(34%)

#### Иргэд (45%)

Жолоочийн хариуцлага:	(11%)
Тээврийн хэрэгсэл:	(19%)
Бусад:	(5%)

#### Орон нутаг (12%)

Мал амьтдын даатгал:	(6%)
Албан журмын даатгал:	(9%)


### 21 АЙМАГ ДАХЬ САЛБАРУУДЫН БАЙРШИЛ



Хамтран ажилладаг давхар даатгагчид, брокерууд



LLOYD'S





# КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА САНХҮҮГИЙН ҮР ДҮН





## Бизнесийн нөхцөл байдал

Бодь Даатгал ХК 2022 онд нийт хөрөнгөө 37%-аар, цэвэр хураамжийг 23%-аар, орлогод тооцсон хураамжийн хэмжээ 16.9%-аар өсгөн зах зээлд эзлэх байр сууриа 11,6%-д хүргэж, тэр дундаа тээврийн хэрэгслийн даатгалын хураамж, хамгийн их нөхөн төлбөрийг олгож салбарын хэмжээнд тэргүүлсэн нь даатгалын салбартаа тэргүүлэгч байр суурийг хадгалсаар байна.




Монголын эдийн засгийн хувьд ч мөн 2022 он шинэ сорилт бүхий жил болж өнгөрлөө. Манай эдийн засаг гадаад орчноос хэт өндөр хамааралтайгаас гадна КОВИД-19 цар тахлын сөрөг нөлөө, ОХУ-Украины хурцадмал байдал нь дэлхийн зах зээл дээрх шатахуун, хүнсний үнийн өсөлт, тээвэр, логистикийн гацаа, нүүрсний экспортын орлогын бууралт, төлбөрийн тэнцлийн хүндрэлээр дамжин төгрөгийн ханшийн сулралт, инфляцын дарамт улам бүр нэмэгдлээ.

Олон улсын байгууллагууд 2022 онд Монгол улсын бодит эдийн засаг 2.5-3.0%-ийн өсөлт үзүүлнэ гэж таамагласан ч эдийн засгийн өсөлт 4.8%-иар өссөн үзүүлэлттэй гарлаа.




БОДИТ ЭДИЙН  
ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ  
/Их наяд төгрөгөөр/



ДААТГАЛЫН  
САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ  
/Тэрбум төгрөгөөр/



БОДЬ ДААТГАЛЫН  
ҮЗҮҮЛЭЛТ  
/Тэрбум төгрөгөөр/



Бид өнгөрсөн онуудад оновчтой зөв, цахим технологиудыг анхлан нэвтрүүлж ирсэн цахим даатгал, цахим нөхөн төлбөрийн систем бүхий томоохон төслүүдийг үргэлжлүүлэн нөхөн төлбөрийн аппликэйшн-ийг бүрэн хэрэгжүүлснээр хэрэглэгчдэд зөвхөн даатгалаа цахимаар хийлгэх төдийгүй хамгийн их цаг зарцуулдаг нөхөн төлбөрийн процессыг зайнаас шийдвэрлэх боломжтой болж, иргэдэд үйлчилгээг дэвшилтэд технологийн тусламжтайгаар хурдан шуурхай хүргэж байна. 2022 онд 14,1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс 92% -аар өсөж, компанийн өмнөх жилүүдийн мөн үеэс дүнгээс хамгийн өндөр дүнд хүрлээ. Энэ нь хэрэгдэгчдэд таатай мэдээ хэдий ч нөгөөтэйгүүр компанийн ашигт ажиллагаанд хамгийн ихээр нөлөөлж, цэвэр ашиг буурсан үзүүлэлттэй гарлаа. Мөн бүх салбарийг хамарсан үнийн өсөлтөөс болж эрүүл мэндийн үйлчилгээний зардал 30 орчим хувь, тээврийн хэрэгслийн сэлбэг бараа 60-70 хувь өссөн нь нөхөн төлбөрийн зардлыг огцом ихээр нэмэгдүүллээ.

Эдгээр нөхцөл байдал, хүндрэлийн жилд бид дотоод зардлыг бууруулах, даатгалын үйл ажиллагааны ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилт тавьж, байгууллагын даатгалын харилцагчийн үйлчилгээ, харилцагч бүрт тохирсон андеррайтингийн бодлогыг хэрэгжүүлж ажилласны дүнд байгууллагын даатгалын хураамж 44%-аар өслөө. Байгууллагын даатгалын харилцагч, хураамжийг нэмэгдүүлэх хүрээнд, томоохон сонгон шалгаруулалтад анхаарал тавьж ажилласан бөгөөд Оюу Толгой ХХК, Эрдэнэс Таван Толгой ХК, Эрдэнэт үйлдвэр, Багануур ХК зэрэг томоохон аж ахуй нэгжүүдийн даатгагчаар шалгарч, хамтын ажиллагааг эхлүүлээд байна.

2021 онд даатгалын салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь буюу даатгалын нэвтрэлт 0.5% байсан бол 2022 онд 1.0% болж өссөн байна. Даатгалын салбар 2022 онд нийт хураамжийн 63.5% буюу 186.1 тэрбум төгрөгийг дотооддоо авч үлдсэн (цэвэр хураамж) байна.

Энэ онд Бодь даатгал ХК гадаадын давхар даатгагчтай нягт хамтран ажиллаж эрсдэлийг шилжүүлэх, фронт оффисоо өргөжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлсний үр дүнд цэвэр хураамжийн орлого өмнөх оноос 23.5%-аар өсөж, 23.6 тэрбум төгрөгт хүрсэн ба салбарын цэвэр хураамжийн 12.7%-ийг эзэлж, зах зээлд эзлэх хувиар 2-т орлоо.

/Сая төгрөгөөр/				/Сая төгрөгөөр/			
Бүтээгдэхүүнээр:	FY21	FY22	YoY%	Бүсээр (сая төг)	FY21	FY22	YoY%
Жолоочийн хариуцлага:	5,978.6	5,257.2	-12.1%	УБ хот иргэд	6,984.6	8,606.0	23.2%
Тээврийн хэрэгсэл:	4,703.3	5,220.9	11.0%	Орон нутаг иргэд	2,191.4	2,739.0	25.0%
Эрүүл мэнд:	3,812.5	8,118.8	113.0%	Нийт иргэд:	9,176.0	11,345.0	23.6%
Хөрөнгө:	1,481.2	1,664.2	11.1%	Хөрөнгө, хариуцлага:	3,886.2	4,806.6	23.7%
Хариуцлага:	1,498.5	1,846.9	23.3%	Эрүүл мэнд:	3,504.4	5,434.8	55.1%
Мал амьтад:	585.4	378.1	-35.4%	Шууд бус (Брокер):	2,589.7	2,064.7	-20.3%
Бусад:	1,096.8	1,164.8	6.2%	Байгууллага нийт:	9,980.3	12,306.1	23.3%
Цэвэр хураамж	19,156.3	23,651.1	23.5%	Цэвэр хураамж:	19,156.3	23,651.1	23.5%

Даатгалын салбарт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгын хүрээнд Монгол Улсад анх удаа “Гэрийн тэжээвэр амьтны даатгал”-ыг гаргаж, санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж, Зах зээлд нэвтрүүлж ажиллалаа. Энэхүү бүтээгдэхүүний даатгалын хураамжийн 1 хувийг “Азтай савар” ТББ болон нохой, муурыг авран хамгаалах үйлсэд хандивлах бөгөөд цаашлаад олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилготой сайн үйлсэд багахан ч болов хувь нэмрээ оруулж, дэмжин ажиллаж байна.

Хөдөө орон нутгийн 21 салбараар дамжуулан борлуулсан бүтээгдэхүүнээс хамгийн их хувийг малын индексжүүлсэн даатгал эзэлдэг бөгөөд 2022 онд нийт бүтээгдэхүүний хураамжийн 23%-г бүрдүүлсэн байна. Салбар нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, борлуулалт үйл ажиллагааг дэмжих, малчин даатгуулагчдад даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн 9 салбарт автомашин үр дүнгийн гэрээгээр шилжүүлж ажиллалаа.



АХА хувь хүний  
эрүүл мэндийн даатгал



Эрүүл мэндийн "Эрхэм"  
даатгал



Тээврийн хэрэгслийн  
даатгал

*\*хөгжүүлж байгаа*

Галын даатгал



Тээврийн хэрэгслийн  
"Шийдэл" даатгал





## Нөхөн төлбөр

2022 онд нийт 14.6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн 15.3 хувь буюу 2.2 тэрбум төгрөгийг давхар даатгагч, үлдсэн 12.1 тэрбум төгрөгийг компани өөрөө хариуцан төлсөн байна. Компанийн 2022 оны хохирлын харьцаа өмнөх оныхоос 10.2 хувиар өсч 73.1 хувьд хүрчээ.

ЦЭВЭР ХУРААМЖИД НОГДОХ НӨХӨН  
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ /ХАРЬЦУУЛАЛТ/



“  
**2022 онд нийт 20,641**  
 даатгуулагчид **14.6**  
**тэрбумын** нөхөн төлбөр  
 олгосон байна.  
 “

/Сая төгрөгөөр/

Зардалд тооцсон нөхөн төлбөрийн дүн	2021	2022	Өсөлт
Жолоочийн хариуцлагын даатгал	4,201.99	5,776.76	37.5%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	2,070.00	2,932.94	41.7%
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	1,620.30	4,025.20	148.4%
Мал амьтдын даатгал	409.48	3.46	-99.2%
Хөрөнгийн даатгал	317.78	12.64	-96.0%
Хариуцлагын даатгал	228.70	4.71	-97.9%
Бусад	15.43	256.18	1560.3%
Нийт	8,671.85	13,011.91	50.0%

## Санхүүгийн байдлын тайлан

Бодь даатгал ХК цэвэр хураамжийн дүнгээр 2021 онд 3-р байранд орж байсан бол 2022 онд эхний 2-т орсон байна. Зуучлалын зардлаа хасаж үзвэл эхний 3 компани ойролцоо дүнтэй цэвэр орлого олсон байна.

Бодь даатгалын зуучлалын зардал, үйл ажиллагааны зардлын харьцаа салбарын дунджаас бага боловч хохирлын харьцаа буюу нөхөн төлбөр олголт салбарын дунджаас өндөр тул даатгалын үйл ажиллагаанаас ашиг багатай ажиллалаа. Хосолсон харьцаа буюу нөхөн төлбөр, үйл ажиллагааны зардлаа орлогод тооцсон хураамжтай харьцуулсан харьцаа салбарын дундаж 105.8%, Бодь 131.8% байна. Бодь даатгалын хохирлын харьцаа салбарын дунджаас 18.8%-р өндөр байгаа нь хосолсон харьцаанд нөлөөлж байна. 2023 онд хохирлын харьцааг бууруулахад анхаарч ажиллаж байна.

(Тэрбум төгрөг)	Бодь даатгал	Эзлэх хувь	Салбарын нийт (Бодь даатгал ороогүй)	Эзлэх хувь
Орлогод тооцсон хураамж	19.9	100%	152.3	100%
Нийт нөхөн төлбөр	14.5	73%	78.2	51%
Үйл ажиллагааны зардал	8.5	43%	66.5	44%
Зуучлалын зардал	3.1	16%	27.5	18%

Хөрөнгө оруулалтын хувьд эрсдэл бага авах, тогтвортой байх бодлоготой тул хөрөнгө оруулалтын өгөөж салбарын дундажтай ойролцоо гарсан. Давхар даатгалын шимтгэлээр 2.3 тэрбум, хүүгийн орлогоос 1.0 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан байна.




## Хувьцааны шинжилгээ

2020 оны 5 сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO (Initial Public Offering) хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааныхаа 15 хувийг санал болгон нийт 5.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлж олон нийтэд нээлттэй компани болсон.

Үзүүлэлт	Тийм
Самбар:	MSE I
Орсон индекс:	ТОП 20
Хяналт, зохицуулалт:	СЗХ, Хөрөнгийн бирж, Аудит
Орлого, ашиг сүүлийн 3 жилд дараалж өссөн эсэх:	тийм
Эдийн засгийн уналтаас хамаарал:	Бага
Шинэ оролцогчийн эрсдэл:	Тусгай зөвшөөрөлтэй, зохицуулалттай салбар
Менежментийн туршлага:	Гүйцэтгэх удирдлага, даатгалын захирал 10 -аас дээш жил ажилласан.

2022 оны 12-р сарын 30-ны хаалтын ханш 131.1



## 2022 Оны голлох үзүүлэлтүүд

Орлогын үзүүлэлтүүд	2020	2021	2022	YoY	2023	2024	2025
	Бодит				Төсөөлөл		
<b>Цэвэр хураамж:*</b>	14,668	19,156	23,651	23%	28,860	31,746	34,921
Орлогод тооцсон хураамж:	14,760	17,061	19,948	17%	23,954	28,889	31,778
Цэвэр нөхөн төлбөр:	6,028	8,984	12,142	35%	12,690	14,444	14,300
<b>Зардалд Тооцсон н.төлбөр:</b>	6,663	8,671	13,011	50%	11,156	15,022	15,571
Гэрээний зардал:	2,150	2,482	3,102	25%	3,656	4,333	4,767
<b>Үйл ажиллагааны зардал:*</b>	6,665	8,246	8,592	4%	8,973	13,000	14,300
Давхар даатгал орлого:	1,158	3,034	2,349	-23%	3,484	3,832	4,216
Хөрөнгө оруулалтын орлого:	1,524	1,901	1,092	-43%	1,709	1,880	2,068
<b>Цэвэр ашиг:</b>	<b>2,071.00</b>	<b>2,339</b>	<b>(1,365)</b>	<b>-158%</b>	<b>2,065</b>	<b>2,246</b>	<b>3,424</b>
Хохирлын харьцаа:	58%	63%	73%	16%	47%	52%	49%
ҮА зардлын харьцаа:	45%	48%	43%	-10%	37%	45%	45%
Гэрээний зардлын харьцаа:	15%	15%	16%	4%	15%	15%	15%
<b>Хосолсон харьцаа: +</b>	<b>118%</b>	<b>126%</b>	<b>132%</b>	<b>4%</b>	<b>99%</b>	<b>112%</b>	<b>109%</b>

## 2022 ОНЫ ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Балансын үзүүлэлтүүд	2020	2021	2022	YoY
	Бодит			
Мөнгөн хөрөнгө:	14,074	14,431	15,654	8.5%
Авлага:	3,530	7,916	5,015	-36.6%
Бусад хөрөнгө	15,071	24,091	11,000	-54.3%
<b>Нийт цэвэр хөрөнгө:*</b>	<b>32,675</b>	<b>46,438</b>	<b>31,669</b>	<b>-32%</b>
Өр төлбөр:	2,406	5,501	5,120	-6.9%
Бусад:	726	1,010	3,220	218.8%
Нөөц сан:+	16,705	26,185	8,435	-67.8%
Эздийн өмч:	13,561	14,751	9,194	-37.7%
<b>Нийт эздийн өмч, өр төлбөр</b>	<b>33,398</b>	<b>47,447</b>	<b>25,969</b>	<b>-45%</b>
Авлагын эргэц (өдөр):	148	86	76	
Өр төлбөр / Эздийн өмч	5.64x	2.68x	1.8x	
<b>Төлбөрийн чадвар</b>	<b>126%</b>	<b>101%</b>	<b>109%</b>	
Price-to-Book (P/E)				
<b>Компанийн үнэлгээ төсөөлөл:</b>	<b>2.18x</b>	<b>3.08x</b>	<b>2.58x</b>	

